Монголын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлийн
2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
хурлын 04 тоот тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ СОНГУУЛИЙН ДҮРЭМ

/нэмэлт, өөрчлөлт 2024/



ГАРЧИГ	ХУУДАС

НЭР ТОМЪЁО 3

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛҮҮД 4

1. Хамрах хүрээ 4
2. Үндсэн зарчмууд, үүрэг хариуцлага 4

II. СОНГУУЛИЙН ХОРООД

3. Үндсэн зарчим 5
4. Сонгууль 5
5. Бүрэлдэхүүн 5
6. Үүрэг 6
7. Сонгуулийн хорооны хурал болон хурлын ирц 7
8. Шийдвэр 7

III. НЭР ДЭВШИХ

9. Нэр дэвших шалгуур 7
10. Зөвлөлд нэр дэвших журам 7
11. Зөвлөлд нэр дэвшигчдийг шалгах 8
12. Зөвлөлд нэр дэвшигчдийн гомдол гаргах журам 8
13. Бусад байгууллагуудад нэр дэвших журам 9
14. Нэр дэвшигчдийн албан ёсны жагсаалтыг мэдээлэх 9

IV. САНАЛ ӨГӨХ

15. Сонгуульт Их хурал хуралдуулах 9
16. Сонгуульт Их хурлын үеийн Сонгуулийн хорооны үүрэг 9
17. Саналын хуудас 9
18. Саналын хайрцаг 10
19. Санал өгөх бүхээг 10
20. Санал өгөх 10

V. САНАЛ ТООЛОХ

21. Ерөнхий зааltууд болон маргаан шийдвэрлэх 10
22. Хүчингүй саналын хуудас 11
23. Зөв бичгийн алдаа 11
24. Санал тоолох болон үр дүнг мэдэгдэх 11
25. Эцсийн дүнг зарлах 12
26. Бичиг баримтын нууцлал ба хадгалалт 12
27. Олон нийтийн нотариат 12

VI. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

28. Бусад заалтууд 12
29. Хүчин төгөлдөр болох нь 12

НЭР ТОМЪЁО

Энэхүү Сонгуулийн дүрэмд ашигласан нэр томъёо нь Монголын Хөлбөмбөгийн Холбооны дүрмийн "Тодорхойлолт" хэсэгт заасан нэр томъёогоор тодорхойлогдоно.

Тэмдэглэл: Энэ дүрэмд заасан хувь хүн гэсэн ойлголт нь бүх төрлийн хүйсийн этгээдийг илэрхийлнэ. Нэг тоон дээр бичигдсэн аливаа нэр томъёо нь олон тоог, мөн олон тоо нь нэг тоог илэрхийлнэ.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1-р зүйл. Хамрах хүрээ

1. Энэхүү Сонгуулийн дүрмийг /цаашид "Дүрэм" эсвэл "Сонгуулийн дүрэм" гэнэ/ МХБХ-ны Зөвлөлийн гишүүд, Хараат бус байгууллагуудын гишүүд болон Их хурлын гишүүдийн холбогдох байгууллагуудын бүхий л сонгуульд нэгэн адил дагаж мөрдөнө.

2-р зүйл. Үндсэн зарчмууд, үүрэг хариуцлагууд

1. Сайн засаглалын зарчим: Энэ зарчмын дагуу эрх мэдлийн хуваарилалт, ардчилал, хараат бус байдал үйлчлэх ба Холбооны сонгуулийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод, шударга байна. Түүнчлэн сонгуулийн бүхий л үйл явцад ашиг сонирхлын аливаа зөрчлийн нөхцөл байдлаас зайлсхийнэ.
2. Төрийн оролцоог хязгаарлах: Энэ зарчмын дагуу МХБХ-ны сонгуулийн үйл ажиллагаа болон Их хурлыг бүрдүүлэхэд төрийн бүхий л оролцоог хориглоно. Мөн төрийн байгууллагын сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг МХБХ-ны сонгуулийн үйл ажиллагаанд мөрдөгдөхгүйгээс гадна МХБХ-ны сонгуулийн дүрэм нь төрийн ямар нэгэн байгууллагаар батлагдаж зөвшөөрөгдөх шаардлагагүй. Түүнээс гадна:
   2.1. МХБХ-ны гишүүн байгууллага нь өөрийн сонгуулийг энэхүү дүрмийн дагуу явуулах ба ~~шаардлагатай тохиолдолд~~ МХБХ-ны зөвшөөрөлтэйгээр өөрийн сонгуулийн журмыг батлах ~~болох~~ бөгөөд уг журам нь дараах агуулгыг заавал багтаана. Үүнд: нэр дэвшигчдийн нэрсийг бүртгэх эцсийн хугацаа, нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, нэр дэвшигчдийн албан ёсны жагсаалтыг мэдээлэх эцсийн хугацаа, санал өгөх журам, саналын хуудас, саналын хайрцаг, санал өгөх бүхээг, мөн сонгуулийн үйл явцыг баталгаажуулах, түүнд гомдол гаргах журмыг тусгасан байна.
   2.2. МХБХ нь энэхүү дүрмийн дагуу өөрийн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа энэ тухайгаа нэг сарын өмнө ОУХБХ болон АХБХ-нд албан ёсоор мэдэгдэнэ. Сонгуулийн тов, нэр дэвших хугацаа, сонгогдох гишүүдийн тоо болон сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хүчин төгөлдөр Сонгуулийн дүрмийн хуулбарын хамт /хэрэв сонгуулийн бусад журам, заавартай бол мөн адил/ ОУХБХ болон АХБХ-нд мэдэгдэнэ.
3. Сонгуулийн дүрэм, заавар нь МХБХ-ны дүрэмд заасан хугацаанд нийцсэн, хоёрдмол утгагүй, тодорхой, байдлаар батлагдсан байна.
4. Сонгуулийн үйл явцад аливаа төрлийн гуравдагч этгээдийн зохисгүй нөлөөллийг зөвшөөрөхгүй. МХБХ нь сонгуулийн үйл явцад гуравдагч этгээдийн зохисгүй нөлөөллийн талаар ОУХБХ болон АХБХ-нд нэн даруй мэдэгдэх ёстой.
5. МХБХ-ны дүрэм, журамд өөрөөр заагаагүй бол МХБХ-ны холбогдох байгууллагын гишүүд сонгуулийн үйл ажиллагаа дуустал чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ХОЁР. СОНГУУЛИЙН ХОРООД

3-р зүйл. Үндсэн зарчим

1. Сонгуулийн хороод нь МХБХ-ны Дүрэм болон энэ дүрэмд заасны дагуу сонгуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих замаар сонгуулийн үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой шийдвэрийг гаргана.
2. Сонгуулийн хороод нь Сонгуулийн хороо /анхан шатны байгууллага/, Сонгуулийн хяналтын хороо /хоёр дахь шатны байгууллага/-ноос бүрдэнэ.
3. Сонгуулийн хороодын гишүүн нь МХБХ-ны аливаа бусад байгууллагын гишүүн байж болохгүй.
4. Сонгуулийн хороодын гишүүн нь МХБХ-ны хөндлөнгийн, хараат бус, бие даасан, шударга /bona fide/ гишүүн байна. Хараат бус гишүүн гэж МХБХ-той аливаа албан болон албан бус харилцаа, холбоо байхгүйг хэлэх бөгөөд МХБХ-ны Дүрэмд заасны дагуу дөрвөн жилийн сонгуульт ажлын хугацаанд МХБХ-ны Зөвлөл, гишүүдийн аль нэг, лиг эсвэл клуб харъяалагдсан компани /байгууллагын хэлбэрээр/-д үүрэг гүйцэтгэх, дээр дурдсан газруудтай бизнесийн харилцааг үүсгэхийг хориглоно.
5. Сонгуулийн хороодын гишүүн нь дараах нөхцөл байдал бий болсон тохиолдолд сонгуулийн үйл ажиллагаанд оролцох болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад санал өгөх гишүүний эрхээс татгалзах үүрэгтэй:
   5.1. Сонгуульт албан тушаалд нэр дэвшиж байгаа бол,
   5.2. Сонгуульд нэрээ дэвшүүлж байгаа хүнтэй гэр бүл, төрөл садангийн холбоотой бол,
   5.3. Төрийн албан тушаал эрхэлж байгаа бол,
   5.4. МХБХ-ны Сахилгын болон Ёс зүйн дүрэмд заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн эсвэл үүсэх магадлалтай тохиолдолд.
6. Сонгуулийн хороодын гишүүн энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд түүнийг Сонгуулийн хороодын гишүүний эрх, үүргээс чөлөөлж, түүний оронд орлох гишүүнийг Сонгуулийн хороодын даргын санал болгосноор Зөвлөл нөхөн томилно.
7. Сонгуулийн хороодын гишүүн нь дараалсан болон дараалаагүй нийт 2-оос дээш удаа сонгогдохгүй.
8. Сонгуулийн хороодын гишүүд ажил үүргээ гүйцэтгэхдээ ямар ч үед шударгаар ажиллана.

4-р зүйл. Сонгууль

1. Сонгуулийн хороодын гишүүд нь энэхүү дүрмийн дагуу МХБХ-ны Их хурлаас 4 жилийн хугацаатай сонгогдоно. МХБХ-ны Их хурал нь Сонгуулийн хорооны 5 үндсэн гишүүн, 2 орлох гишүүн, мөн Сонгуулийн хяналтын хорооны 3 үндсэн гишүүн, 2 орлох гишүүнийг сонгоно.

5-р зүйл. Бүрэлдэхүүн

1. Сонгуулийн хороо нь дарга, дэд дарга болон гурван /3/ гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд МХБХ-ны дотоод бүтцийн байгууллагад хамаарна.

2. Сонгуулийн хороодын гишүүдийн олонхын саналаар дарга, орлогч даргыг сонгоно.
3. МХБХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга нь Сонгуулийн хороодын нарийн бичгийн даргаар ажиллана. Нарийн бичгийн дарга нь Сонгуулийн хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, захиргааны холбогдох асуудлыг хариуцан ажиллах үүрэгтэй бөгөөд Сонгуулийн хороодын хуралд зөвлөх үүрэгтэй оролцож болно.
4. Сонгуулийн хороодын нэг буюу түүнээс дээш гишүүд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гишүүний үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Зөвлөл түүнийг чөлөөлж оронд нь орлох гишүүнийг Сонгуулийн хороодын даргын санал болгосноор нөхөн томилно.
5. Хорооны гишүүн нь сонгуульт албан тушаалд нэр дэвшиж байгаа бол сонгуулийн хорооны үйл ажиллагааны шуурхай, тасралтгүй байдлыг хангах, орлох гишүүнийг цаг алдалгүй нөхөн томилох зэрэг нөхцлийг бүрдүүлэх зорилгоор энэ талаараа урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
6. Сонгуулийн хороод нь Ерөнхий нарийн бичгийн даргын газрын албан хаагчдын туслалцааг авч болно. Энэ тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргын газрын тухайн албан хаагч нь аливаа сонгуульт албан тушаалд нэр дэвшээгүй мөн ашиг сонирхлын зөрчилгүй байвал зохино.

6-р зүйл. Үүрэг

1. Сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавихтай холбоотой бүх үүргийг хариуцна. Тодруулбал:
   1.1. МХБХ-ны дүрэм болон энэ дүрэм, бусад холбогдох журам, зааврыг дагаж мөрдөн, хэрэгжүүлэх;
   1.2. МХБХ-ны байгууллагуудын сонгуульт холбогдох журам, зааварчилгаа нь ОУХБХ-ны дүрэм, журам, шийдвэр, зааварчилгаа болон МХБХ-ны дүрэм, энэ дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах;
   1.3. Сонгуулийн дүрэмд заасан хугацааг чанд дагаж мөрдөн, хэрэгжүүлэх;
   1.4. Нэр дэвшигч болон сонгуулийн үр дүнтэй холбоотой мэдээллийг МХБХ-ны гишүүдэд, шаардлагатай тохиолдолд хэвлэл мэдээлэл, олон нийтэд хүргэх;
   1.5. Нэр дэвших журмыг хангах /нэр дэвшүүлэх хугацаа, журмын талаар мэдээлэл хүргүүлэх, нэр дэвшигчдийг бүртгэх, шалгах, нэр дэвшигчдийн албан ёсны жагсаалт гаргах, түүнийг мэдэгдэх/;
   1.6. Сонгуулийн үйл ажиллагааг захиргаа болон техникийн талаас зохион байгуулах;
   1.7. МХБХ-ны сонгуулийн үеэр саналын эрх бүхий Их хурлын төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтад хяналт тавих;
   1.8. Энэ дүрэмд заасан зорилгоор томилогдсон нийтийн нотариатчийн хяналт дор санал өгөгчдийг баталгаажуулах;
   1.9. Санал хураах, тоолох журмыг удирдах, хяналт тавих.
2. Сонгуулийн хяналтын хороо нь энэхүү дүрэмд заасан бүтцийн байгууллагуудын сонгуулийн үйл явц, шийдвэртэй холбоотойгоор Сонгуулийн хорооноос гаргасан шийдвэрийг давж заалдах журмаар гаргасан гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцэх үүрэгтэй хоёр дахь шатны байгууллага байна.
3. Сонгуулийн зохион байгуулалтыг МХБХ хариуцан гүйцэтгэнэ.

7-р зүйл. Сонгуулийн хороодын хурал болон хурлын ирц

1. Сонгуулийн хороодын дарга нь хороодын хурлыг зарлан хуралдуулах эрхтэй байна.
2. Гишүүдийн ердийн олонх /50 хувиас дээш/-оор хурлын ирц бүрдэнэ. Хурлын ирц бүрдсэн тохиолдолд Сонгуулийн хороод тухайн асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргана.

8-р зүйл. Шийдвэр

1. Сонгуулийн хороод нь хуралд оролцсон гишүүдийн ердийн олонх (50%-иас дээш)-ын саналаар шийдвэр гаргана. Хэрвээ гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хороодын даргын санал шийдвэрлэх үүрэгтэй байна. Хороодоос гарсан шийдвэрүүдийг хурлын тэмдэглэлд тусгах бөгөөд уг тэмдэглэлд хороодын дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
2. Сонгуулийн хорооны шийдвэрт гомдол гаргахдаа зөвхөн Сонгуулийн хяналтын хороонд гаргах бөгөөд энэ талаар төрийн эрх бүхий байгууллагад гомдол мэдүүлэхгүй.

ГУРАВ. НЭР ДЭВШИХ

9-р зүйл. Нэр дэвших шалгуур

1. ОУХБХ болон МХБХ-ны дүрэмд өөрөөр заагаагүй бол сонгуульд нэр дэвшигч нь дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:
   1.1. Монгол Улсад амьдарч байгаа, 18-аас дээш насны Монгол Улсын иргэн байх;
   1.2. Ял шийтгэлгүй байх;
   1.3. Хөлбөмбөгтэй холбоотой бодлого, санхүү, үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцоотой байх.
2. Тухайн сонгуульт албан тушаалын онцлог, гүйцэтгэх чиг үүргээс шалтгаалан нэр дэвшигчдэд нэмэлт болон тусгай шаардлагуудыг МХБХ-ны дүрэм, Сонгуулийн дүрэм болон бусад журмаар тодорхойлно.
3. Сонгуулийн хороо нь нэр дэвших шалгуур (МХБХ-ны дүрмийн зохих зүйл, заалтад нийцүүлэн боловсруулсан) болон нэр дэвшиж буй албан тушаал бүрт бүрдүүлэх бичиг баримтуудын хамт багтаасан бүрэн жагсаалтыг МХБХ-ны дүрэмд заасан хугацаанд багтаан нээлттэй нийтэлнэ.

10-р зүйл. Зөвлөлд нэр дэвших

1. Хэрэв өмнө нь Холбооны Их хурлаас шийдвэрлэж батлаагүй л бол нэр дэвшигч нь ямар ч хэлбэрийн хураамж, төлбөр төлөхгүй. Хэрэв Их хурлаас төлбөр хураамж төлөхөөр батлагдсан бол тэр нь зөвхөн тухайн сонгуулийн зохион байгуулалтын зардлыг төлөх хэмжээтэй байх бөгөөд урьдчилан хэлэлцэн тохиролцсон байна.
2. Нэр дэвшигчдийн хүсэлт материалыг Ээлжит Сонгуульт Их хурал болохоос хамгийн ихдээ хуанлийн 30 хоногийн өмнө, цахим шуудангаар илгээсэн бол хүлээн авсан тухай хариу и-мэйл хүссэн, шуудангаар бол хүлээн авсан өдрийн тэмдэглэлийг тэмдэглэсэн, биечлэн хүргэж ирсэн бол хүлээн авсан тухай хариу мэдэгдлийг авсан байхаар МХБХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт

илгээнэ.

3. Нэр дэвшигчийн хүсэлт материал нь тухайн нэр дэвшигчийн талаарх дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд:
   1.1. Сонгуульд нэр дэвшүүлэх тухай гишүүн байгууллагын албан бичиг;
   1.2. Сонгуульд нэр дэвшигчийн намтар /маягтын дагуу гаргасан/, цээж зураг болон нэр дэвшигчдэд тавигдах шаардлага хангаж байгаа тухай мэдээлэл;
   1.3. Иргэний үнэмлэхний хуулбар.
4. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь нэр дэвшигчийн материалыг хүлээн авсан даруйд, МХБХ-ны Дүрмийн 38.4 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн материалын хянуулахаар Сонгуулийн хорооны нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

11-р зүйл. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг шалгах

1. Сонгуулийн хороо нь Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн материалыг хүлээж авснаас хойш гурван (3) хоногт багтаан шалгаж, хэрвээ нэр дэвшигчийн материал дутуу, нэмэлт мэдээлэл шаардлагатай бол нэмэлт хоёр (2) хоногийг сунгаж буй талаар албан бичиг өгнө. Хэрвээ энэхүү нэмэлт хугацаа дууссахад шаардлагатай нэмэлт материалаа өгөөгүй нэр дэвшигчийн материалыг хүчингүйд тооцож мэдэгдэнэ.
2. Сонгуулийн хороо нь нэр дэвшигчийн хүсэлт материалыг хянаж нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг нэр дэвшигчийн материал ирүүлэх хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэнэ.

12-р зүйл. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч гомдол гаргах

1. Сонгуулийн хяналтын хороо нь дарга, үндсэн хоёр (2) болон орлох хоёр (2) гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг МХБХ-ны Их хурлаас сонгоно. Хорооны дарга нь заавал хуульч мэргэжилтэй байна.
2. Сонгуулийн хорооны шийдвэрийн талаарх гомдлыг төрийн байгууллага эсвэл бусад байгууллагад гаргахгүй бөгөөд нэн түрүүнд зөвхөн Сонгуулийн хяналтын хороонд гаргана.
3. Нэр дэвшигч болон нэр дэвшүүлсэн гишүүн байгууллага нь үндэслэл бүхий гомдлыг Сонгуулийн хорооны шийдвэрийг хүлээн авснаас хойш хуанлийн 4 хоногийн дотор цахим шуудангаар илгээсэн бол хүлээн авсан тухай хариу и-мэйл хүссэн, шуудангаар бол хүлээн авсан өдрийн тэмдэглэлийг тэмдэглэсэн, биечлэн хүргэж ирсэн бол хүлээн авсан тухай хариу мэдэгдлийг авсан байхаар илгээнэ. МХБХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь гомдлыг ирсэн даруйд Сонгуулийн хяналтын хороонд илгээнэ.
4. Сонгуулийн хяналтын хороо нь гомдлыг хүлээж авснаас хойш хуанлийн тав (5) хоногийн дотор хянаж, шийдвэрлэн, мөн хугацаанд багтаан нэр дэвшигчтэй харилцаж мэдээлнэ.
5. Сонгуулийн хяналтын хорооны шийдвэрийг хянуулахаар Монголын Олон улсын ба Үндэсний спортын арбитрт гомдол гаргах эрхтэй.

13-р зүйл. МХБХ-ны бусад байгууллагад нэр дэвших үйл явц

1. МХБХ-ны Аудит болон Дүрэм, журмын хяналтын нэгж, Сонгуулийн хороод, Эрх зүйн байгууллагуудад нэр дэвшигчдийн хүсэлт материалыг МХБХ-ны Зөвлөлөөс тухайн ээлжит сонгуульт Их хурал болохоос хамгийн ихдээ хуанлийн 30 хоногийн өмнө Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлнэ.
2. Нэр дэвшигчдийн материалыг хүлээн авснаас хойш хуанлийн 15 хоногийн дотор багтаан Сонгуулийн хорооноос тухайн албан тушаалд тавигдах албан ёсны шалгуурт нэр дэвшигчид тэнцэж байгаа эсэх талаар мэдэгдэнэ. Хэрвээ нэг (1) юмуу олон нэр дэвшигчид тэнцээгүй тохиолдолд Зөвлөлөөс тухайн албан тушаалд нэмэлтээр өөр хүн нэр дэвшүүлнэ.
3. Дээрх байгууллагын гишүүдийн сонгуулийг багцаар нь явуулна. Сонгуульт Их хурал эхлэхэд сонгогдох шаардлагатай албан тушаал, тэдгээрт нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг агуулсан багц материалыг гишүүдэд тараасан байх ёстой.
4. Эдгээр гишүүдийн сонгох явцад гишүүд суудалдаа заавал байх ёстой бөгөөд санал тоологчийн тэдний өмнө авчрах хайрцагт хийх байдлаар саналаа өгнө. Энэхүү явцыг сонгуулийн хорооны аль нэг гишүүн сайтар хянаж байх ёстой.
5. Бүх гишүүд саналын хайрцагт саналаа хийсний дараа сонгуулийн хорооны гишүүд их хурлын нийт төлөөлөгчдийн өмнө санал тооллогыг явуулж, үр дүнг Их хурлын гишүүдэд албан ёсоор мэдээлнэ.

14-р зүйл. Нэр дэвшигчдийн албан ёсны жагсаалтыг зарлах

1. Сонгуулийн хороо нь бүртгүүлсэн албан ёсны нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг эцсийн байдлаар Сонгуульт Их хурал болохоос хуанлийн 10 хоногийн өмнө МХБХ-ны гишүүдэд хүргүүлнэ. Нэр дэвшигчдийн жагсаалтыг хэвлэл мэдээллээр нийтэлж болох бөгөөд мөн хэрэв шаардлагатай гэж үзвэл төрийн байгууллагад мэдээлж болно.

ДӨРӨВ. САНАЛ ӨГӨХ ЖУРАМ

15-р зүйл. Сонгуульт Их хурал хуралдуулах

1. Сонгуульт Их хурлыг МХБХ-ны дүрэмд заасны дагуу хуралдуулна. Сонгуулийн холбогдох цаг хугацааг олон нийтэд нээлттэй зарлах бөгөөд шаардлагатай гэж үзвэл холбогдох төрийн байгууллагад мэдэгдэж болно.

16-р зүйл. Сонгуульт Их хурлын үеэр Сонгуулийн хорооны үүрэг

1. Сонгуулийн хороо нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
   1.1. Санал өгөх эрхтэй сонгогчдыг баталгаажуулах;
   1.2. МХБХ-ны сонгуульт Их хурлын үеэр сонгуулийн үйл явцад хяналт тавих;
   1.3. Саналын хуудасны тоог тоолох;
   1.4. Саналын хуудасны хүчинтэй эсвэл хүчингүйд тооцох асуудлаар шийдвэр гаргах;
   1.5. Сонгуульт их хурлын үеэр санал хураах журамтай холбоотой аливаа асуудлаар тодорхой шийдвэр гаргах;
   1.6. Сонгуулийн талаар албан ёсны тэмдэглэл хөтөлж, түүнийг Холбооны гишүүдэд хүргүүлэх;

1.7. Сонгуулийн албан ёсны дүнг зарлах;
1.8. Шаардлагатай тохиолдолд хэвлэлийн бага хурал зохион байгуулах.

17-р зүйл. Саналын хуудас

1. МХБХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын газраас Сонгуулийн хорооны хяналт удирдлаган дор саналын хуудсыг боловсруулж, хэвлүүлнэ. Саналын хуудас нь агуулга, бичилт, хэлбэрийн хувьд саналын эрх бүхий Их хурлын төлөөлөгчид саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байна.
2. Сонгуулийн хуудас нь сонгуулийн үе шат бүрт өөр өөр өнгөтэй байна.

18-р зүйл. Саналын хайрцаг

1. Санал хураалтын үйл явц эхлэхээс өмнө саналын хайрцаг ил тод байх ёстой. Их хурал эхлэхийн өмнө төлөөлөгчдөд хайрцгийг нээж харуулсны дараа битүүмжлэн лацдаж, Сонгуулийн хорооны гишүүдэд ил харагдахаар газар байрлуулна.
2. Санал хураалтын туршид Сонгуулийн хорооны гишүүдийн аль нэг нь саналын хайрцагт хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ.

19-р зүйл. Санал өгөх бүхээг

1. Сонгуульд санал өгөх эрх бүхий Их хурлын төлөөлөгчдийн саналаа нууцаар, чөлөөтэй өгөх эрхийг нь хангах үүднээс саналын хуудас бөглөх бүхээгийг бэлтгэнэ.
2. Тус бүхээг нь бүгдэд ил тод харагдахаар байрлах боловч санал өгч буй гишүүнийг саналаа нууцаар өгөх боломжийг бүрэн хангасан байна.

20-р зүйл. Санал өгөх

1. Сонгуулийн хорооны дарга нь холбогдох дүрэм, журамд заасанчлан, санал өгөх журам (саналын хайрцаг, санал өгөх хуудас, хүчинтэй болон хүчингүй саналын хуудас, санал тоолох, сонгуулийн үр дүн гэх мэт)-ыг Их хурлын төлөөлөгчдөд ойлгомжтой байдлаар тайлбарлана.
2. Сонгуулийн хорооны дарга санал өгөх эрх бүхий Их хурлын төлөөлөгчдийг ээлжээр дуудан, сонгууль явагдаж буй танхимын тайзны урд талд урьж гаргана.
3. Дуудагдсан Их хурлын төлөөлөгч танхимын урд гарч саналын эрх бүхий Их хурлын төлөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд гарын үсгээ зурсны дараа саналын хуудсаа хүлээн авна.
4. Их хурлын төлөөлөгч саналын бүхээгт өөрийн саналын хуудсаа зааврын дагуу засваргүй бөглөнө. Саналын бүхээгт гар утас, видео камер, аудио бичлэгийн төхөөрөмж зэргийг авч орохыг хориглоно.
5. Их хурлын төлөөлөгч бөглөсөн саналын хуудсаа хайрцагт хийж, сонгуулийн жагсаалтанд гарын үсэг зурсны дараа буцаж суудалдаа сууна.
6. Санал өгсөн Их хурлын төлөөлөгчдийн бүртгэл дууссан даруйд санал тоолох үйл явц эхэлнэ. Сонгуулийн хорооны нэг гишүүн Их хурлын нийт гишүүдийн өмнө саналын хайрцгийг нээнэ.

ТАВ. САНАЛ ТООЛОХ

21-р зүйл. Ерөнхий заалтууд болон маргаан шийдвэрлэх

1. Зөвхөн Сонгуулийн хорооны гишүүд санал тоолох үйл явцад оролцоно. Саналын бүхий л явц (саналын хайрцаг нээх, саналын хуудас тоолох, санал тоолох) нь их хурлын төлөөлөгчид ажиглаж болохуйц байдалд явагдана.
2. Саналын хуудсыг хүчинтэй эсхүл хүчингүйд тооцох, саналыг хүчинтэй эсхүл хүчингүйд тооцох, тэмдэглэл хөтлөлт, ~~бөлөн~~ сонгуулийн үр дүнг мэдээлэх болон санал тоолох үйл явцтай холбоотой үүссэн аливаа маргааныг Сонгуулийн хороо шийдвэрлэнэ. ~~бөгөөд Сонгуулийн хорооны шийдвэр нь эцсийнх байна.~~

22-р зүйл. Хүчингүй саналын хуудас

1. Дараах тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно. Үүнд:
   1.1. Сонгуулийн хорооноос гаргасан албан ёсны таних тэмдэггүй саналын хуудас;
   1.2. Нэр дэвшигчийн нэрнээс өөр ямар нэгэн тэмдэглэгээ хийсэн саналын хуудас;
   1.3. Үл ойлгогдохоор буюу баллаж засварласан саналын хуудас;
   1.4. Таних тэмдэг тэмдэглэгээтэй саналын хуудас.
2. Сонгуулийн хорооны дарга хүчингүй саналын хуудасны ард талд хүчингүйд тооцсон шалтгааныг бичиж (улаан өнгөөр), гарын үсэг зурж баталгаажуулна.

23-р зүйл. Зөв бичгийн дүрмийн алдаа

1. Албан ёсны нэр дэвшигчийг тодорхойлох боломжгүй зөв бичгийн алдаатай саналыг хүчингүйд тооцож болно.

24-р зүйл. Санал тоолох болон үр дүнг мэдэгдэх

1. Саналын хайрцгийн битүүмжлэлийг нээсэн даруйд, Сонгуулийн хорооны гишүүд саналын хуудсыг тоолж, тэдний хүчинтэй эсэхийг шалгана. Хэрвээ хайрцаг дахь саналын хуудасны тоо тараасан саналын хуудастай тэнцүү эсвэл түүнээс бага байвал, санал хүчинтэй байна. Хэрвээ саналын хуудасны тоо тараасан саналын хуудаснаас илүү гарсан тохиолдолд санал хураалтыг хүчингүй болохыг зарлаж, дээр дурдсан журмын дагуу санал хураалтыг нэн даруй дахин эхлүүлнэ.
2. Саналын хуудсыг шалгаж дууссаны дараа, сонгуулийн хорооны гишүүд нэр дэвшигч тус бүрийн саналыг тоолно.
3. Тооллого дуусч баталгаажсаны дараа, Сонгуулийн хорооны дарга тооллогын үр дүнг Их хуралд албан ёсоор мэдээлнэ.
4. МХБХ-ны дүрэм болон энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 2 дахь (дахин) санал хураалт явуулах шаардлагатай болсон тохиолдолд дахин санал хураалт явуулах үндэслэлийн талаар Их хуралд мэдэгдэнэ.
5. Санал хураалтын үе шат бүрийн дараа Сонгуулийн хорооны дарга албан ёсны үр дүнг Их хуралд зарлан мэдээлнэ.
6. Ерөнхий нарийн бичгийн дарга нь хураагдаж тоологдсон саналын хуудсыг уг зорилгоор тусгайлан дугтуйлна. Дугтуйн дээр Сонгуулийн хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулж битүүмжилнэ. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь

эдгээр дүгтуйг архивт хадгална.

25-р зүйл. Эцсийн дүнг зарлах

1. Сонгууль дууссаны дараа Сонгуулийн хорооны дарга санал хураалтын үр дүнгийн талаар Их хуралд албан ёсоор мэдэгдэх бөгөөд энэ тухай тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлд Сонгуулийн хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
2. Эцсийн тэмдэглэлийг Сонгуулийн хорооны бүх гишүүдэд, шаардлагатай тохиолдолд төрийн байгууллагуудад тараана. Мөн тэдгээрийг МХБХ-ны Их хурлын тэмдэглэлд оруулна.

26-р зүйл. Бичиг баримтын нууцлал ба хадгалалт

1. Сонгуулийн хороо болон Сонгуулийн хяналтын хороо нь холбогдох бүх баримт бичиг, түүн дотроо сонгуулийн явцад тэдэнд ирсэн бүх баримт бичгийг хадгалж архивлуулахаар Ерөнхий нарийн бичгийн даргын газарт албан ёсоор хүлээлгэн өгнө.
2. Сонгуулийн хороо болон Сонгуулийн хяналтын хорооны бүх гишүүд нь тэдэнд ирсэн, сонгуулийн үеэр нэмэлтээр гарсан бүх л мэдээлэл болон баримт бичгийн нууцлалыг болон тэнд дурдсан нууцыг чандлан хадгална. Энэ үүргийг холбогдох сонгуулийн явцтай холбоотойгоор хугацаагүйгээр хүлээнэ. Гишүүд сонгуулийн явцад тэдэнд ирсэн цахим болон бусад ямар ч бичиг баримтыг өөртөө хадгалж үлдэхгүй.

27-р зүйл. Олон нийтийн нотариат

1. Нотариатч болон арбитраас түүнтэй адилтгах хуулийн эрх олгосон этгээд Их хуралд үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн тэмдэглэлийг хөтлөх үүрэгтэйгээр оролцоно. Тэрхүү этгээд нь төлөөлөгчдийг таних, баталгаажуулах, мөн санал хураалтын явц нь зохих дүрэм журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавина.

ЗУРГАА. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

28-р зүйл. Бусад заалт

1. Сонгуулийг зохион байгуулахтай холбоотой энэ дүрэмд заагаагүй аливаа асуудлын талаар Сонгуулийн дүрэм болон МХБХ-ны Дүрмийн ерөнхий агуулга, зорилт, заалтын дагуу Сонгуулийн хороо нь хариуцан шийдвэрлэнэ.

29-р зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү дүрмийг МХБХ-ны Зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар батлагдсан бөгөөд батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.